



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН  
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2025/13/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



**Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр**

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

**Аудитын менежер У.Батсүрэн**

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

**Ахлах аудитор С.Батцэцэг**

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

**Аудитор Г.Золбаяр**

Утас: 70373089 Цахим хаяг: ZolbayarG@audit.gov.mn

Дархан-Уул аймаг

2025 он

## ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Статистикийн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/13/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дархан-Уул аймаг 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn  Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn  Аудитор: Г.Золбаяр Утас: 70373089 Цахим хаяг: zolbayarg@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....</b>	<b>4</b>
1.1 Аудитыг онцолсон хэсэг	
1.2 Аудитын гол асуудал	
<b>2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....</b>	<b>5</b>
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	14
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....</b>	<b>15</b>
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	15
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	16
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН .....</b>	<b>18</b>
4.1 Ерөнхий зүйл .....	18
4.2 Материаллаг байдал .....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	19
4.5.1 Завсрын аудитын талаар.....	19
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>	<b>20</b>
5.1 Төлбөрийн акт .....	20
5.2 Албан шаардлага .....	20
5.3 Зөвлөмж.....	20
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....</b>	<b>22</b>

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГНХ,ЗДНХөрөнгө	Засгийн газрын нөөц хөрөнгө, Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059,  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.17 № 32

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА  
Г.ХУРЦБИЛЭГ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Статистикийн хэлтсийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Статистикийн хэлтсийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Үндэсний статистикийн хорооны даргын Б/23, Үндэсний статистикийн тамгын газрын даргын Б/235 тоот тушаалаар орон нутагт тогтвор, суурьшилтай тасралтгүй 5 болон түүнээс дээш жил ажиллаж байгаа 4 албан хаагчдад нийт 32,490.0 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон байна.

### Аудитын гол асуудал

Тайлант онд урсгал үйл ажиллагаанаас гадна 155,805.5 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авч, байгууллагын чиг үүргийн дагуу жилийн эцсийн мал тооллого, өрхийн нийгэм эдийн засаг, ажиллах хүчний судалгаа, хөдөө аж ахуйн тооллогыг явуулсан байна.

### Бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дархан-Уул аймгийн Статистикийн хэлтсийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 44 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 97.29 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,493,773.10</u></b>	<b><u>1,533,661.06</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>		<b>13,887.96</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		13,887.96
33103	ХАОАТ-ын авлага		13,887.96
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>1,493,773.10</b>	<b>1,519,773.10</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>1,493,773.10</b>	<b>1,519,773.10</b>
35410	Бичиг хэргийн материал		
35470	Бусад хангамжийн материал	1,493,773.10	1,519,773.10
3505	Мал амьтад	-	-
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>102,590,330.26</u></b>	<b><u>81,785,816.46</u></b>
<b>37</b>	<b>УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>		
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>102,590,330.26</b>	<b>81,785,816.46</b>
391	Газар		
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	102,590,330.26	81,785,816.46
390202	Авто-тээврийн хэрэгсэл	105,000,000.00	105,000,000.00
39020201	Хуримтлагдсан элэгдэл	(37,000,000.06)	(45,000,000.10)
390203	Машин тоног төхөөрөмж (компьютер)	83,108,676.65	83,108,676.65
39020301	Хуримтлагдсан элэгдэл	(49,159,866.33)	(61,869,340.09)
390204	Тавилга, аж ахуйн эд хогшил	9,288,602.80	9,288,602.80
39020401	Хуримтлагдсан элэгдэл	(8,647,082.80)	(8,742,122.20)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>104,084,103.36</u></b>	<b><u>83,319,477.52</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>104,084,103.36</u></b>	<b><u>83,319,477.52</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>104,084,103.36</b>	<b>83,319,477.52</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	-	
51101	Өмч: - төрийн	104,084,103.36	83,319,477.52
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	104,084,103.36	83,319,477.52
51210	Өмнөх үеийн үр дүн	124,888,617.36	104,084,103.36
51220	Тайлант үеийн үр дүн	(20,804,514.00)	(20,764,625.84)
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-	-
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>104,084,103.36</u></b>	<b><u>83,319,477.52</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>344,476,265.00</b>	<b>446,471,841.50</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>344,476,265.00</b>	<b>446,471,841.50</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	200,894,000.00	290,666,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	200,894,000.00	290,666,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	143,582,265.00	155,805,541.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,270,400.00	45,055,900.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	127,311,865.00	110,749,641.50
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>365,280,779.00</b>	<b>467,236,467.34</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>365,280,779.00</b>	<b>467,236,467.34</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	361,182,931.83	432,105,841.35
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	194,642,617.10	255,751,605.89
210101	Үндсэн цалин	102,236,557.37	113,586,621.30
210102	Нэмэгдэл	68,708,386.13	100,595,984.59
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,844,000.00	22,815,000.00
210104	Урамшуулал	8,613,673.60	18,754,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	21,800,152.00	32,766,118.37
210201	Тэтгэврийн даатгал	15,132,946.27	23,060,419.33
210202	Тэтгэмжийн даатгал	1,640,097.86	3,170,371.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,444,252.46	1,089,221.33
210204	Ажилгүйдлийн даатгал	324,659.58	1,089,221.33
210205	Эрүүл мэндийн даатгал	3,258,195.83	4,356,885.35
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	27,138,636.40	17,428,058.55
210401	Бичиг хэрэг	1,449,300.00	3,725,000.00
210402	Тээвэр, шатахуун	9,773,140.00	9,906,178.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,716,196.40	3,796,880.55
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	200,000.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	200,000.00	1,118,500.00
210604	Урсгал засвар	200,000.00	1,118,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	18,363,904.00	13,403,642.96
210702	Дотоод албан томилолт	18,363,904.00	13,403,642.96
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	77,833,108.33	87,083,451.78
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	76,758,634.33	85,684,753.78
210803	Даатгалын үйлчилгээ	478,800.00	538,698.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	107,274.00	53,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	22,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	488,400.00	784,800.00

Статистикийн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	21,204,514.00	24,554,463.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	400,000.00	3,749,950.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	20,804,514.00	20,804,513.80
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	4,097,847.17	35,130,625.99
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	500,000.00	33,390,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	32,490,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	900,000.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	3,597,847.17	1,740,625.99
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,597,847.17	1,740,625.99
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(20,804,514.00)</b>	<b>(20,764,625.84)</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	-	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(20,804,514.00)</b>	<b>(20,764,625.84)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>344,476,265.00</b>	<b>446,471,841.50</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>344,476,265.00</b>	<b>446,471,841.50</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	200,894,000.00	290,666,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	200,894,000.00	290,666,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	143,582,265.00	155,805,541.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,270,400.00	45,055,900.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	127,311,865.00	110,749,641.50
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>344,476,265.00</b>	<b>446,471,841.50</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>344,476,265.00</b>	<b>446,471,841.50</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>340,378,417.83</b>	<b>411,341,215.51</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	189,762,073.80	255,569,445.22
210101	Үндсэн цалин	102,245,289.75	99,756,000.00
210102	Нэмэгдэл	64,211,646.46	116,213,058.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,844,000.00	17,943,181.82
210104	Урамшуулал	8,221,137.59	21,657,205.40
210105	Гэрээт ажлын хөлс	3,240,000.00	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	23,563,931.88	32,962,167.00
210201	Тэтгэврийн даатгал	16,546,398.46	24,205,367.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,762,923.33	2,189,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,401,538.66	1,094,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	349,224.68	1,094,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,503,846.75	4,378,400.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	26,627,036.40	13,123,680.55
210401	Бичиг хэрэг	1,137,700.00	3,185,000.00
210402	Тээвэр, шатахуун	9,373,140.00	5,515,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,716,196.40	3,822,880.55
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	400,000.00	599,950.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	200,000.00	4,998,500.00
210604	Урсгал засвар	200,000.00	4,998,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	18,491,904.00	11,832,000.00
210702	Дотоод албан томилолт	18,491,904.00	11,832,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	81,533,471.75	92,855,422.74
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	80,147,397.75	91,456,724.74
210803	Даатгалын үйлчилгээ	478,800.00	538,698.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	107,274.00	53,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	22,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	800,000.00	784,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	200,000.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	200,000.00	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,097,847.17</b>	<b>35,130,625.99</b>

Статистикийн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	500,000.00	33,390,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	32,490,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	900,000.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	3,597,847.17	1,740,625.99
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,597,847.17	1,740,625.99
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	=	=
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	=	=
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	=	=
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	-
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>			124,888,617.36		124,888,617.36
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-		-
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>			<b>124,888,617.36</b>		124,888,617.36
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт			-		-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт			-		-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			-		-
C07	Тайлант үеийн үр дүн			(20,804,514.00)		(20,804,514.00)
C08	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>			<b>104,084,103.36</b>		104,084,103.36
D01	<b>2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>			<b>104,084,103.36</b>		104,084,103.36
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-		-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>			<b>104,084,103.36</b>		104,084,103.36
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт			-		-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт			-		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			-		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D08	Тайлант үеийн үр дүн			(20,764,625.84)		(20,764,625.84)
D09	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>			<b>83,319,477.52</b>		83,319,477.52

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	290,666,300.00	289,307,715.77	1,358,584.23
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	290,666,300.00	289,307,715.77	1,358,584.23
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	257,195,300.00	255,917,715.77	1,277,584.23
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	218,917,900.00	218,520,287.22	397,612.78
210101	Үндсэн цалин	99,756,000.00	99,756,000.00	-
210102	Нэмэгдэл	79,163,900.00	79,163,900.00	-
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,808,000.00	17,943,181.82	(135,181.82)
210104	Урамшуулал	22,190,000.00	21,657,205.40	532,794.60
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	27,364,800.00	27,364,800.00	-
210201	Тэтгэврийн даатгал	18,608,000.00	18,608,000.00	-
210202	Тэтгэмжийн даатгал	2,189,200.00	2,189,200.00	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,094,600.00	1,094,600.00	-
210204	Ажилгүйдлийн даатгал	1,094,600.00	1,094,600.00	-
210205	Эрүүл мэндийн даатгал	4,378,400.00	4,378,400.00	-
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,023,400.00	2,645,430.55	377,969.45
210401	Бичиг хэрэг	1,000,000.00	1,000,000.00	-
210402	Тээвэр, шатахуун	588,600.00	588,600.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	784,800.00	456,880.55	327,919.45
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	650,000.00	599,950.00	50,050.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,000,000.00	4,998,500.00	1,500.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	4,998,500.00	1,500.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	1,000,000.00	990,000.00	10,000.00
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	990,000.00	10,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,398,700.00	1,398,698.00	2.00
210803	Даатгалын үйлчилгээ	538,700.00	538,698.00	2.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	53,200.00	53,200.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	784,800.00	784,800.00	-
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	490,500.00	-	490,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	196,200.00	-	196,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	294,300.00	-	294,300.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	33,471,000.00	33,390,000.00	81,000.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	33,471,000.00	33,390,000.00	81,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	32,490,000.00	32,490,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	981,000.00	900,000.00	81,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	290,666,300.00	289,307,715.77	1,358,584.23

Статистикийн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	290,666,300.00	289,307,715.77	1,358,584.23
131001	Улсын төсвөөс санхүүжих	290,666,300.00	289,307,715.77	1,358,584.23
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>7.00</b>	<b>7.00</b>	-
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>7.00</b>	<b>7.00</b>	-
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-
620002	Гүйцэтгэх ажилтан	4.00	4.00	-
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00	-

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>155,423,499.74</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>155,423,499.74</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	155,423,499.74
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	37,049,158.00
210102	Нэмэгдэл	37,049,158.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	5,597,367.00
210201	Тэтгэврийн даатгал	5,597,367.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	10,478,250.00
210401	Бичиг хэрэг	2,185,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,927,250.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,366,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	10,842,000.00
210702	Дотоод албан томилолт	10,842,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	91,456,724.74
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	91,456,724.74
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>155,423,499.74</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	155,423,499.74
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	44,673,858.24
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	110,749,641.50

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Статистикийн хэлтэс нь статистикийн мэдээлэл цуглуулж, боловсруулж эцсийн хэрэглэгчдэд түгээх үйлчилгээ үзүүлэх зорилготой бөгөөд албан ёсны статистикт төрийн их өгөгдлийг ашиглах, бэлтгэх ажлыг хангах, статистикийн мэдээллийн хэрэгцээ ашиглалтыг нэмэгдүүлэх зорилт дэвшүүлэн төр, эдийн засаг, нийгмийн бодлогын удирдлагын үйл ажиллагаа, статистик хэрэглэгчдийг чанартай тоон мэдээллээр ханган нотолгоонд суурилсан бодлого шийдвэрийн залгамжийг тасралтгүй хадгалан статистикийн чадавхаараа дэлхийд тэргүүлэх чиглэлийг тодорхойлон үйл ажиллагаа явуулж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тогтоол зэргийг үйл ажиллагаандаа дагаж мөрдөж байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн төрийн сан холбогдох санхүүгийн баримт материал, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Иймд төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Статистикийн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

#### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Статистикийн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 83,319.4 мянган төгрөг байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	13.8	13.8
Бараа материал	1,493.7	1,519.7	26.0
Үндсэн хөрөнгө	102,590.3	81,785.8	(20,804.5)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>104,084.1</b>	<b>83,319.4</b>	<b>(20,764.6)</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	104,084.1	83,319.4	(20,764.6)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>104,084.1</b>	<b>83,319.4</b>	<b>(20,764.6)</b>

Авллага дансны үлдэгдэл 13.8 мянган төгрөг бүртгэсэн нь тайлант хугацаанд албан хаагчдад олгосон цалин, нэмэгдэл хөлснөөс суутгасан хувь хүний орлогын албан татварын бүрэн төвлөрүүлээгүйгээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 26.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд бусад хангамжийн материал буюу интернетийн дотоод сүлжээтэй холбоотой модем, хатуу диск гэх мэт бараа материалын үлдэгдэлтэй холбоотой байна.

Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө нэмэгдээгүй бөгөөд элэгдлийн зардалтай холбоотойгоор буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга байхгүй бөгөөд тайлант оны үр дүнгээр засгийн газрын хувь оролцоо данс буурчээ.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Төсвийн шууд захирагч 2024 оны төсвийн төсөлд нийт зарлагыг 285,522.0 мянган төгрөгөөр тооцож, санхүүжих эх үүсвэрийг улсын төсвөөс бүрдүүлэхээр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Тухайн төсвийн төслийг хэвээр баталсан бөгөөд тайлант онд ажилтнуудын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан төсвийг 5,144.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 290,666.3 мянган төгрөгөөр тодотгосон байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэх 290,666.3 мянган төгрөгийг 100 хувь улсын төсвөөс бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 290,666.3 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос урсгал үйл ажиллагаанд 289,307.7 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 1,358.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 289,307.7 мянган төгрөг буюу 99.5 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлаас 397.6 мянган төгрөг, хангамжийн бараа материалын зардлаас 377.9 мянган төгрөг, урсгал засвар болон томилолтын зардлаас 11.5 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 490.5 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас 81.0 мянган төгрөг нийт 1,358.6 мянган төгрөг тус тус зарцуулаагүйтэй холбоотой байна.

**Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл**

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувиар/
1	<b>70405-Албан ёсны статистик, эрдэм шинжилгээ судалгааны ажил</b>	<b>290,666.3</b>	<b>289,307.7</b>	<b>1,358.6</b>	<b>99.5</b>
1.1	80101 - Үндсэн үйл ажиллагааны зардал	257,195.3	255,917.7	1,277.6	99.5
1.2	80215 – Эрдэм шинжилгээ судалгааны ажил	-	-	-	-
1.3	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	33,471.0	33,390.0	81.0	99.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн ЗДТГ-аас жилийн эцсийн мал тооллогын үйл ажиллагаанд зориулж 3,000.0 мянган төгрөг, орон нутгийн нэмэгдэлд 42,055.9 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас өрхийн нийгэм эдийн засаг, ажиллах хүчний судалгаа, хөдөө аж ахуйн тооллого, бусад судалгаатай холбоотойгоор 110,749.6 мянган төгрөг, нийт 155,805.3 мянган төгрөгийн санхүүжилт төвлөрч, 155,423.5 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдсэн зардлын санхүүжилтийг төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

**3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

**3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Статистикийн хэлтсийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Золбаяр гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Статистикийн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дугаар сарын 24-ний өдрийн 99 тоот албан бичгээр ирүүлсэн.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 245,801.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,458.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.7-д заасны дагуу бараа үйлчилгээний бусад зардал буюу хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг ашиглаагүй хэмнэж 490.5 мянган төгрөгийг хэмнэсэн байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудаст төсөв, гүйцэтгэлийн 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.3, 6.1.4 дэх заалтуудтай нийцэхгүй байна.

##### **Шийдвэрлэсэн нь:**

Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж байх, алдааг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Тус газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өнгөрсөн оны аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар нийт 290,680.2 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илрүүлж аудитын явцад залрууллаа. Үүнд:

1. Санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд урсгал үйл ажиллагааны санхүүжилт 290,663.3 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн орлогоор бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, 14.4 дэх хэсэг, ангилал батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул улсын төсвийн санхүүжилт дансанд бүртгэж залруулав.
2. Санхүүгийн тайланд ХХОАТ-н 13.9 мянган төгрөгийн авлагыг тайлагнаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь заалт, иж бүрэн байх, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул санхүүгийн тайланд ХХОАТ-ын авлага дансанд бүртгэж залруулав.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал илрээгүй болно.

### 5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

### 5.3 Зөвлөмж

Санхүүгийн тайлагналтай холбоотой зөвлөмж өгөөгүй болно.

Тайлангийн 4.4.1 дэх хэсэгт дурдсан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5<sup>2</sup>-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхиадуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

<sup>2</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.



## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд урсгал үйл ажиллагааны санхүүжилтийг нэмэлт санхүүжилтийн орлого гэж буруу бүртгэсэн.	1	290,666.3	-		1	290,666.3	1	290,666.3	-	-	-	-
Санхүүгийн тайланд ХХОАТ-н авлагыг тайлагнаагүй.	1	13.9	1	13.9	-		1	13.9	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>290,680.2</b>	<b>1</b>	<b>13.9</b>	<b>1</b>	<b>290,666.3</b>	<b>2</b>	<b>290,680.2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудаст Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал, Санхүүгийн тайлан, Байгууллагын батлагдсан төсөв, Дараа жилийн төсвийн төсөл мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>